



ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/78

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн хууль, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2017 оны 3/828 дугаар албан бичгээр өгсөн зөвлөмж, чиглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиудыг хэрэгжүүлэхэд баримтлах заавар”-ыг хавсралтаар баталсугай.

2. Зааврыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор аймаг, дүүрэг (нийслэл)-ийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсүүдийг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллахыг Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилт, судалгааны газар (Ц.Ганцэцэг)-т, холбогдох програм хангамжийг боловсруулж 2017 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн дотор хэлтсүүдэд хүргүүлэхийг Мэдээллийн технологийн төв (Г.Хүрэлбаатар)-д, зааврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Д.Ганзориг)-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга (Г.Саран)-д даалгасугай.

ДАРГА

Д.ЗОРИГТ

1000325





ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗАР


ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ЦЭРГИЙН АЛБА  
ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН  
ТУХАЙ ХУУЛИУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЗААВАР

Баримт бичгийн дугаар: ЗВР-НДБХСГ- 01- 2017

Баталсан: Эрүүл мэнд, нийгмийн даатгалын  
ерөнхий газрын дарга Д.Зоригт

Хянасан: Нийгмийн даатгалын бодлогын  
хэрэгжилт, судалгааны газрын  
дарга  Ц.Ганцэцэг

Боловсруулсан: Нийгмийн даатгалын бодлогын  
хэрэгжилт, судалгааны газрын  
ахлах мэргэжилтэн  С.Лхагвадорж

Нийгмийн даатгалын бодлогын  
хэрэгжилт, судалгааны газрын  
мэргэжилтэн  М.Бямбадулам

Эх хувь	Дардас
Хяналттай хувь	
Хуулбар ба хяналттай хувь	
Хүчингүй хувь	




ЭМНДЕГ Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд ЗВР-НДБХСГ-01-2017 нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиудыг хэрэгжүүлэхэд баримтлах заавар

### Баримт бичгийн үзүүлэлт

Журмын хариуцагч	Тушаалын дугаар	Баталсан огноо	Мөрдөж эхлэх огноо	Хуудасны тоо
ЭМНДЕГ-ын НДБХСГ	A/78	2017-05-03	2017-03-02	9

### Өөрчлөлтийн тухай тэмдэглэл

Хувилбар	Өөрчлөлт оруулсан огноо	Өөрчлөлтийн утга	Өөрчлөлт оруулсан ажилтан
Хувилбар 1	2016-12-28 2017-01-26	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хууль, Цагдаагийн албаны тухай шинэчилсэн найруулга, Монгол Улсын Хилийн тухай шинэчилсэн найруулга	М.Бямбадулам
Хувилбар 2			
Хувилбар 3			
Хувилбар 4			
Хувилбар 5			
Хувилбар 6			





## АГУУЛГА

1. Зорилго
2. Хамрах хүрээ
3. Хамаарах талууд
4. Баримт бичгийн хариуцагч
5. Үндсэн хэсэг
6. Хариуцлага



Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2017 оны 05 дугаар сарын 03 -ны өдрийн А/78 дугаар тушаалын хавсралт

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛИУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЗААВАР

*НЭГ. Зорилго*

1.1.Энэхүү зааврын зорилго нь Улсын Их Хурлаас 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр баталсан Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хэрэгжүүлэхэд оршино.

1.2.Энэ заавраар зохицуулсан асуудал нь Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой урьд хүргүүлсэн журам, заавар, чиглэл, аргачлалаас зөрүүтэй бол энэхүү зааврыг дагаж мөрдөнө.

*ХОЁР. Хамрах хүрээ*

2.1.Энэхүү зааврын хамрах хүрээ нь Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Цэргийн албаны тухай, 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдөр батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Монгол Улсын хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Монгол Улсын хилийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 3/828 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвлөмж, чиглэл зэрэг болно.

*ГУРАВ. Хамаарах талууд*

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын газар, аймаг, дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсүүд, зэвсэгт хүчин, хилийн цэрэг, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, цагдаа, тагнуул, шүүхийн шинжилгээ, авлигатай тэмцэх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагууд



## ДӨРӨВ. Баримт бичгийн хариуцагч

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилт, судалгааны газар.

### ТАВ. Үндсэн хэсэг

5.1.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг дор дурдсанаар хэрэгжүүлнэ. Үүнд:

5.1.1.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан цагдаагаас бусад зэвсэгт хүчин, хилийн цэрэг, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын цэргийн алба хаагчдын цэргийн алба хаах насны дээд хязгаарыг Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн хуульд зааснаар баримтална.

*Санамж<sup>1</sup>:Цэргийн албаны тухай хуульд зааснаар цэргийн алба хаах насны дээд хязгаар нь ахлагч, дунд офицер бол 47, ахлах офицер бол 52, дээд офицер бол 57, эмэгтэй алба хаагч бол 47 (офицерийн албаны цол харгалзахгүйгээр) байна.*

5.1.2.Цагдаагийн алба хаагчдын цэргийн алба хаах насны дээд хязгаарыг 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдөр батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгад зааснаар баримтална.

*Санамж<sup>2</sup>:Цагдаагийн албаны тухай хуульд зааснаар цагдаагийн алба хаах насны дээд хязгаар нь цагдаагийн бага цолтой алба хаагч бол 47, дунд цолтой алба хаагч бол 52, ахлах цолтой алба хаагч бол 55, дээд цолтой алба хаагч бол 57, эмэгтэй алба хаагч бол 47 (офицерийн албаны цол харгалзахгүйгээр) байна.*

5.1.3.Энэ зааврын 5.1.1, 5.1.2-т зааснаас бусад тагнуул, шүүхийн шинжилгээ, авлигатай тэмцэх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын цэргийн алба хаах насны дээд хязгаарыг Цэргийн албаны тухай хуульд зааснаар мөрдөнө.

5.2.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийг хэрэгжүүлэхдээ Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь хэсэгт заасан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдэд дор дурдсанаар хэрэгжүүлнэ. Үүнд:

5.2.1.Цэргийн тэжээгчээ алдсаны тэтгэврийг шинээр болон өөрчлөн тогтоохдоо Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг баримтална.





5.2.2.Хуулийн энэхүү заалтыг хэрэгжүүлэхдээ нас барсан тэжээгч нь хоёулаа цэргийн алба хаагч байсан тохиолдолд мөрдөнө. Харин 2 тэжээгчийн нэг нь цэргийн алба хаасан, нөгөө нь энгийн байгаа тохиолдолд хөдөлмөрийн хөлсийг нэгтгэн тэжээгчээ алдсаны тэтгэврийг өөрчлөн тогтоохгүй.

5.2.3.Хоёр тэжээгч нь зэрэг нас барснаар тэжээгчийн тэтгэврийг анх тогтоох тохиолдолд Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6-д заасан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдэд тэжээгчээ алдсаны тэтгэврийг нас барсан хоёр тэжээгч цэргийн алба хаагчийн авч байсан цалин хөлсний нийлбэрээс мөн хуулийн 14 дүгээр зүйлд заасан хувь хэмжээгээр бодож тогтооно.

5.2.4.Цэргийн тэжээгчээ алдсаны тэтгэврийг нас барсан 2 тэжээгчийн цалингийн нийлбэрээс өөрчлөн тогтоохдоо эхний тэжээгчийн дундаж цалин дээр хоёр дахь тэжээгчийн дундаж цалинг нэмсэн нийлбэрээс Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасныг баримтална.

*Санамж<sup>3</sup>:Хоёр дахь тэжээгчийн дундаж цалинг тооцохдоо Засгийн газрын 2014 оны 15 дугаар тогтоолоор баталсан “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээ болон цалингийн итгэлцүүрийг шинэчлэн тогтоох тухай” итгэлцүүрийг баримтална.*

*Санамж<sup>4</sup>:Хоёр тэжээгчийн дундаж цалингийн нийлбэр нь тэтгэвэр авагчийн тэтгэврээ өөрчлөн тогтоолгох хүсэлт гаргах үеийн тэтгэвэр тогтооход баримтлах сарын хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээнд хүрээгүй тохиолдолд нийлбэр дүнгээс, илүү гарсан тохиолдолд дээд хэмжээгээр хязгаарлаж тэтгэврийг өөрчлөн тогтооно.*

*Санамж<sup>5</sup>:Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.2 дахь заалтад заасан шалтгаанаар тэжээгч нь нас барсан тохиолдолд тэжээгчээ алдсаны тэтгэврийг шинээр болон өөрчлөн тогтоохдоо уг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасан хувь хэмжээгээр нэмэгдүүлэн тооцно.*

*Санамж<sup>6</sup>:Эхний тэжээгч нь Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.2 дахь заалтад заасан шалтгаанаар нас барсан, 2 дахь тэжээгч нь уг хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад заасан шалтгаанаар нас барсан тохиолдолд тэжээгчээ алдсаны тэтгэврийг шинээр болон өөрчлөн тогтоохдоо уг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасан хувь хэмжээг бууруулахгүйгээр тооцно.*

*Санамж<sup>7</sup>:Хоёр тэжээгчийн 1995 оноос өмнөх хугацааны цалингийн баримт олохгүй тохиолдолд тэтгэврийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэгт заасны дагуу Хүн*



амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/49, А/105 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан тэтгэвэр тогтоолгоход баримтлах “зэвсэгт хүчний” ажил мэргэжлийн жишиг цалинг Засгийн газрын 2014 оны 15 дугаар тогтоолоор баталсан “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээ болон цалингийн итгэлцүүрийг шинэчлэн тогтоох тухай” итгэлцүүрээр өсгөсөн нийлбэрээс Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан хувь хэмжээгээр тогтооно.

Санамж<sup>8</sup>: Хэрэв аль нэг тэжээгчийн 1995 оноос өмнөх хугацааны цалингийн баримт олдохгүй тохиолдолд “зэвсэгт хүчний” жишиг цалинг баримтлан нөгөө тэжээгчийн дундаж цалинтай нэгтгэн тэжээгчээ алдсаны тэтгэврийг тогтооно.

5.3. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасныг Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар буцаан үйлчлэхээр зохицуулсан тул Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн хууль батлагдахаас өмнө нас барсан цэргийн алба хаасны болон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчийн Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдэд өргөдөл, холбогдох баримт бичгийг үндэслэн тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоож олгоно.

5.4. Энэ зааврын 5.3-т заасны дагуу тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох иргэдийн хүсэлтийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэгт заасны дагуу өөрчлөн шийдвэрлэнэ.

5.5. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг дор дурдсанаар хэрэгжүүлнэ. Үүнд:

5.5.1. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсэгт заасан нөхцөл болзлыг хангасан цэргийн алба хаагчийн иргэний байгууллагад нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан 1 жилийг 6 сар цэргийн байгууллагад ажилласан хугацаанд шилжүүлж нэгтгэн тооцож, цэргийн алба хаасны бүрэн буюу хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтооно. Энэ тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа 1 жил хүрээгүй бол 6 сард шилжүүлэн нэмэгдүүлэхгүй.

5.5.2. 2010 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн хууль хүчин төгөлдөр болох хүртэл хугацаанд цэргийн алба хаасны тэтгэвэр авагч нь цэргийн тэтгэвэр тогтоолгохын өмнө иргэний байгууллагад ажилласан жилээ цэргийн алба хаасан хугацаанд оруулан тооцуулах хүсэлт гаргасан тохиолдолд цэрэг, энгийн жилийг нэгтгэн тооцож, түүний тэтгэврийг Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийг баримтлан Нийгмийн







даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.2 дахь хэсэгт заасны дагуу өөрчлөн тогтооно.

*Санамж<sup>9</sup>:Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан болзлыг хангасан цэргийн алба хаагчийн цэргийн алба хаасан хугацаан дээр энгийн жилээс шилжүүлэн тооцсон хугацааг нэмж цэргийн алба хаасны тэтгэврийг өөрчлөн тогтооно.*

*Санамж<sup>10</sup>:Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасан болзлыг хангасан алба хаагчийн цэргийн алба хаасан хугацааг энгийн жилээс шилжүүлэн тооцсон хугацаатай нэгтгэн тооцоход уг хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан хугацаа (25, 20 (23, 20))-г хангаж байвал мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь хэсэг (80%+1.5%+0.125%)-т зааснаар тэтгэврийг өөрчлөн тогтооно.*


*Санамж<sup>11</sup>:Санамж 10-т зааснаар нэгтгэн тооцсон хугацаа нь цэргийн алба хаасны бүрэн тэтгэвэр тогтоох болзол нөхцөл (25, 20 (23, 20))-ийг хангаагүй тохиолдолд цэргийн алба хаасны хувь тэнцүүлсэн тэтгэврийг жилийг нь нэмж өөрчлөн тогтооно.*

5.5.3.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2010 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар тэтгэвэр тогтоолгосон цэргийн алба хаасны тэтгэвэр авагч Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулиар 1990-2000 оны хугацааг нөхөн тооцуулсан бол энэ зааврын 5.5.1-д заасны дагуу нөхөн тооцуулсан 1 жилийг 6 сард шилжүүлэн тэтгэврийг өөрчлөн тогтооно. Энэ тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлсөн хугацаа 1 жил хүрээгүй бол 6 сард шилжүүлэн нэмэгдүүлэхгүй.

5.6.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд:

5.6.1.Цэргийн байгууллагад ажиллаж байгаад халагдсанаас хойш ажилгүй байх үедээ тахир дутуу болсон эсвэл нас барсан цэргийн алба хаагчийн 1995 оноос хойш хугацаанд ногдох тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын шимтгэлийг Засгийн газрын 1994 оны 212 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам”-ын 3 дахь хэсэгт заасны дагуу тооцож, нийгмийн даатгалын санд шилжүүлэн авч Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 7, 12 дугаар зүйлд заасны дагуу тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтооно. Энэ тохиолдолд тухайн иргэний цэргийн байгууллагад ажилласан жилийг 6 сараар нэмэгдүүлэн тооцохгүй.

*Санамж<sup>12</sup>:Энэ зааврын 5.6.1-д заасан хугацааны нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой баримт бичгийг тооцооллын хамт Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэлийн газарт ирүүлнэ.*





5.7. Улсын Их Хурлаас 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр баталсан Монгол Улсын Хилийн тухай шинэчилсэн найруулга, Монгол Улсын хилийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд зааснаар Хил хамгаалах байгууллагад ажиллаж байгаад 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдөр баталсан Хилийн боомтын тухай хуулиар Гадаадын иргэн, харъяатын байгууллагад шилжүүлсэн хилийн цэргийн алба хаагчдын 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл энгийнээр ажилласан хугацааг цэргийн жинхэнэ алба хаасан хугацаанд оруулан тооцож, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтооно.

*Санамж<sup>13</sup>: Зааврын 5.7-д заасан нэр бүхий 261 хилийн цэргийн алба хаагчдын 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл энгийнээр ажилласан хугацааг цэргийн жинхэнэ алба хаасан хугацаанд оруулан тооцож цэргийн алба хаасны тэтгэвэр тогтооно.*

*Санамж<sup>14</sup>: Хил хамгаалах ерөнхий газарт Гадаадын иргэн, харъяатын газраас шилжин ирсэн нэр бүхий 261 хилийн цэргийн алба хаагчийн жагсаалтад ороогүй иргэний Гадаадын иргэн, харъяатын газарт ажилласан хугацааг цэргийн алба хаасан хугацаанд оруулан тооцохгүй.*

5.8. Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 86 дугаар зүйлийн 86.2-т заасан цагдаагийн алба хаагчийн албадан эрүүлжүүлэх, саатуулах байр, улсын онц чухал объектын хамгаалалтад болон замын хөдөлгөөн зохицуулах, эргүүл, харуул, жижүүрийн албанд ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар, цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар тус тус тооцохоор заасныг энэ хууль хүчин төгөлдөр болсон 2017 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс мөрдөнө.

5.9. Энэ зааврын 5.8-д заасан цэргийн алба хаасан хугацааг шилжүүлэн нэмэгдүүлэх зохицуулалт нь Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон гүйцэтгэх ажилтан, замын хөдөлгөөний зохицуулагчид хамаарахгүй болно.

*Санамж<sup>15</sup>: 2017 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс өмнө цагдаагийн алба хаагчийн албадан эрүүлжүүлэх, саатуулах байр, улсын онц чухал объектын хамгаалалтад болон эргүүл, харуул, жижүүрийн албанд ажилласан 1 жилийг 1 жил 2 сараар тооцуулан тэтгэвэр тогтоолгосон цэргийн тэтгэвэр авагч энэ зааврын 5.9-д зааснаар цэргийн алба хаасан хугацаагаа нэмэгдүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу тэтгэвэрийг нь өөрчлөн тогтооно.*

5.10. Улсын Их Хурлын 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсон Тахарын албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3-т заасан албан тушаалд ажиллаж байсан Тахарын алба хаагчийн хугацааг цагдаагийн ахлах



болон дунд цолны албан тушаалд, мөн хуулийн 25.4-т заасан албан тушаалд ажиллаж байсан Тахарын алба хаагчийн хугацааг цагдаагийн бага цолны албан тушаалд ажилласнаар тус тус тооцно.

*Санамж<sup>16</sup>: Тахарын албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3-т "Тахарын албаны төв байгууллагын дарга нь тэргүүн тахар, тэргүүн дэд дарга нь тэргүүн шадар тахар, дэд дарга нь шадар тахар, тойргийн тахарын албаны дарга нь тойргийн тахар, тойргийн тахарын албаны дэд дарга нь тойргийн шадар тахар, нэгжийн дарга нь тахар цолтой байна" гэж заасан тул энэхүү цолыг цагдаагийн ахлах болон дунд цолтой адилтгаж үзнэ.*

*Санамж<sup>17</sup>: Тахарын албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-т бусад алба хаагч нь туслах тахар цолтой байна гэж заасны дагуу бусад тахарын алба хаагчийг цагдаагийн бага цолны албан тушаалд ажилласнаар тооцно.*

*Санамж<sup>18</sup>: Тахарын албанаас Цагдаагийн байгууллагад шилжин ирсэн нэр бүхий 367 тахарын алба хаагчийн жагсаалтад ороогүй иргэний Тахарын албанд ажилласан хугацааг цагдаагийн алба хаасан хугацаанд оруулан тооцохгүй.*

5.11.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг 2017 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс, Монгол Улсын Хилийн тухай шинэчилсэн найруулгыг 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс тус тус дагаж мөрдөнө.

### ЗУРГАА.Хариуцлага

6.1.Энэхүү заавар болон холбогдох хууль, тогтоомж зөрчсөн тохиолдолд үүсэх хариуцлагыг тухайн гэм буруутай албан тушаалтан хүлээнэ.



---oOo---